

## **Петро Матад Лимитед (“Петро Матад” эсвэл “Компани”)**

### **Хайгуул болон Өрөмдлөгийн Үйл Ажиллагааны Талаархи Шинэчилсэн Мэдээлэл**

Петро Матад (AIM:MATD) нь Монгол Улсын зүүн хэсэгт байрлах ХХ талбайн Давсан Толгойн цооногийн хайгуул болон өрөмдлөгийн үйл ажиллагааны талаар шинэчилсэн мэдээллийг хүргэж байна.

#### *Давсан Толгой – 3 (цаашид “ДТ-3” гэх) цооногийн өрөмдлөгийг эхлүүлсэн тухай*

ДТ-3 цооногийн өрөмдлөгийг Монгол Улсын орон нутгийн цагаар 2010 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 18:00 цагт эхлүүллээ. Цооногийг ойролцоогоор 1,200 метрийн гүнд хүртэл босоо чиглэлд өрөмдөхөөр төлөвлөөд байна.

2010 оны 10 дугаар сарын 17-ны үдээс хойш цооногийн анхны бэхэлгээний янданг суулгах 345 метрийн гүнд хүргэсэн бөгөөд цооногийг үргэлжлүүлэн өрөмдөж, нийт төлөвлөсөн гүнд нь хүргэх явцад хоёр дахь болон сүүлийн бэхэлгээний янданг суулгана.

ДТ-3 цооног нь Монгол Улсын зүүн хэсэгт байрлах Бүтээгдэхүүн Хуваах Гэрээт ХХ талбайд Петро Матадын 2010 онд явуулах өрөмдлөгийн гурван хөтөлбөрийн хүрээнд өрөмдлөг хийгдэх гурав дахь хайгуулын цооног юм. Энэхүү цооног нь ДТ-1 цооногоос баруун урд зүгт 8.6 км, ДТ-2 цооногоос баруун урд зүгт 7.7 километрийн зайд байрлана.

Өмнөх хоёр цооногийн өрөмдлөгөөр Давсан Толгойн гүдэн бүтцийн (атираа) оройн хэсгийн дагуух дэд гүдэн бүтцийн өндрийг шалгасан бөгөөд үүний үр дүнд 100 гаруй метрийн өндөртэй нүүрсустөрөгчийн багана илэрсэн. ДТ-3 цооногийг Давсан Толгойн гүдэн бүтцийн оройн хэсэгт байрлуулсан. ДТ-3 цооногийн Цагаанцавын Формацийн дээд хэсэг нь ДТ-1 цооногийн Цагаанцавын Формацийн дээд хэсгээс ойролцоогоор 150 метрийн өндөрт өргөгдсөн байгаа учир ДТ-3 цооногийн өрөмдлөгөөр дээрхи нүүрсустөрөгчийн баганы нийт өндрийг тодорхойлох юм. Мөн энэхүү өрөмдлөгөөр Дээд Зүүнбаянгийн Формацийн гүдэн бүтцэт (атираат) хураагуур болон ан цавжсан ул чулуулагт нүүрсустөрөгч хуримтлагдсан эсэхийг шалгана.

#### *Давсан Толгой-1 цооногийн (“ДТ-1” гэх) Шинжилгээний Үр дүн*

ДТ-1 цооногоос авсан дээжүүдийн тос үүсгэх дулааны болон шингэний ормын шинжилгээний хариуг хүлээж авсан ба уг цооногийн дээжийн шинжилгээний шаардлагатай бүх хариуг үүгээр авч дууслаа.

Шингэний ормын туршилтаар нүүрсустөрөгчийн гажил бүхий хоёр бүс тогтоогдсон байна. Эхний бүс нь өрөмдлөгийн явцад илрээгүй бөгөөд Дээд Зүүнбаян Формацийн элсэн чулуун хэсгийн 810 метрээс 850 метрийн хооронд тогтоогдсон. Хоёр дахь бүс нь 1080-1180 метрт, Цагаанцавын элсэн чулуу болон улны хувирмал чулуулагт илэрсэн.

Зүүнбаянгийн Формацийн тосны оромд (шигдэц) хуурай хий, цууны хүчил болон дэгдэмхий шинжтэй өөр бусад бодисууд агуулагдаж байгаа бөгөөд тэдгээр нь Зүүнбаянгийн Формацийн тос/усны заагаас доошоо уналтай байгааг харуулж байна.

Цагаанцавын Формаци болон түүний доод талын ул чулуулаг дахь шингэний ормын (шигдэц) тархац нь 1,080 метрээс 1,105 метрийн хооронд хуурай хийн шинж чанартай нүүрсустөрөгчийн үелсэн багана, 1,110 метрээс 1,180 метрийн хооронд нойтон хий болон тосны бүрэлдэхүүн хэсэг байгааг харуулж байна. Шингэний ормын шинжилгээгээр ДТ-1 цооногийн өрөмдлөгөөр тосны бүст нэвтэрсэн гэсэн дүгнэлтэнд хүрч байгаа нь ажиглалтын дүнд тогтоогдсон тосны илрэл, өрөмдлөгийн шаварт агуулагдсан хийн шинж тэмдэг, тооцоолж байсан нүүрсустөрөгчийн ханалттай тохирч байгаа юм.

Давсан Толгойн гүдэн бүтэц (атираа) нь газрын тос, байгалийн хий болон Тамсагийн сав газрын илүү гүн бөгөөд тос үүсэхэд илүү тохиромжтой, дулаан хэсгүүдээс гарч буй нүүрсустөрөгчийн хуримтлагдаж буй гол хэсэг юм. Витринитын ойлтын утга 580 метрт 0.44, 1,070 метрт 0.53, Температурын хамгийн их утга (Тmax) 1,070 метрт 428°C байгаа нь Давсан Толгойн оройн дагуух нефтийн үүсгэгч чулуулаг нь тос боловсроход хангалттай дулаан биш болохыг харуулж байна. ДТ-1 цооногт агуулагдаж буй нүүрсустөрөгч, ялангуяа хуурай болон нойтон төлөвт хийн ормын (шигдэц) хувьд, хотгорын хамгийн гүнээс буюу хий үүсгэгч цонхон доторхи үүсгэгч чулуулгаас дээшээ шилжих шаардлагатай байгаа юм.

“Тоног төхөөрөмж, хүн хүчээ дайчлан ДТ-3 цооногийн өрөмдлөгийн ажлыг шуурхай эхлүүлсэн гэрээт компани болон Компанийн техникийн багийнхандаа баяр хүргэх нь зүйтэй. Өрмийн талбайд өвлийн уур амьсгал эрт орж, агаарын температур шөнөдөө бууран хасах хэмд хүрч байна. Цооногийн эхний бэхэлгээний яндангийн угсралтыг шуурхай хийж, гүйцэтгэсэн нь сайшаалтай хэдий ч бид өвлийн уур амьсгалын эрчимжилтийн улмаас үүсч болзошгүй техник технологи, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой асуудлуудаас урьдчилан сэргийлж, талбайн нөхцөл байдлыг хянаж байна.

Бид нэмэлт өрмийн цамхаг болон цооногийн туршилтын туслах үйлчилгээний цамхагийг хөлслөн өрөмдлөгийн ажлаа энэ оны төгсгөл хүртэл бололцоогоороо гүйцэтгэхийг хичээж байна. Бид цаашдын ажлаа зохих гэрээлэгч нараар гүйцэтгүүлнэ гэдэгт найдаж байгаа ч хөгжлийнхээ эхний шатанд яваа газрын тосны үйлчилгээний салбарт гарч болзошгүй хүндрэлүүдийг анхааралдаа авч байгаа.” хэмээн Компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас МакГэй ДТ-3 цооногийн өрөмдлөгийн ажлын талаар дүгнэж хэллээ.

Мөн тэрээр ДТ-1 цооногийн дээжийн шинжилгээний үр дүнгийн талаар тайлбарлахдаа “Эдгээр шинжилгээний үр дүнгүүд нь Давсан Толгой дахь нүүрсустөрөгчийн “гал зуух” буюу эх үүсгүүрээсээ хол зайд нүүдэллэн шилжиж, Давсан Толгойн Цагаанцавын Формацийг цэнэглэсэн тухай цооногийн өмнөх мэдээллийг тоон хэмжээний хувьд баталгаажуулж байгаа юм. Зүүнбаянгийн Формаци дахь өмнө нь илрээгүй нүүрсустөрөгчийн шинж тэмдгүүдийг илрүүлсэн нь мөн нааштай үр дүн юм. Эдгээр үр дүнгүүд нь бидэнд хэтийн төлөв бүхий нөөц баялагийн энэ талын эрсдэлийг бууруулахад илүү баталгаа өгч байна.” гэлээ.

Энэхүү шинэчилсэн мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүгэн хянаж, зассан болно. Доктор Күүгэн нь Хойд Америк болон олон улсын газрын тосны хайгуул, ашиглалтын салбарт 29 жил ажилласан туршлагатай Газрын тосны геологич юм.

Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

*Компанийн талаархи нэмэлт мэдээллийг :*

Петро Матад Лимитед  
Ерөнхий Гүйцэтгэх Захирал - Даглас Жэй МакГэй (Douglas J. McGay)  
+976 11 331099

Уэст Хаус Секюритиз Лимитед (Westhouse Securities Limited)  
Ричард Бати/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)  
+44 (0)20 7601 6100

*Мэдээллийн хянан тохиолдуулагч нарт:*

*Петро Матад Лимитед компанийн тухай*

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах тухай гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол Улсын зүүн хэсэгт орших 14,250 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий газрын тосны ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол Улсын төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 хавтгай дөрвөлжин километр талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.